



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар A/89

Улаанбаатар хот

Г Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн
удирдах, гүйцэтгэх албан тушаалтны
албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангиалал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай нийтлэг журам”, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 7-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 105 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 32 дугаар тушаал, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн “Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт орсондой холбогдуулан аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн хэмжил зүйн хяналтын улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Сорьцын хяналтын улсын байцаагч бөгөөд Ахлах мэргэжилтний (Хүний нөөц, дотоод хяналтын асуудал хариуцсан) албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Бүтээгдэхүүн, баталгаажуулалтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Мэргэжилтэн /Сургалт мэдээлэл, салбар сан, архив бичиг хэрэг/-ний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн даргын 2021 оны 182 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.УУГАНБАЯР

